

СЭТГҮҮЛ ЗҮЙН ДҮРСЛЭХ ЯРИАНЫ ГАЙХАМШИГ

Д. Батжаргал *

Түлхүүр үг: Эх сурвалжийн дүрслэх яриа, ардын дүрслэлийн хэл, хүч нэмэгдүүлэх аялга үг, түүнийг сэтгүүл зүй, утга зохиолын бүтээлд оновчтой зөв ашиглах

Радио судлаач, доктор Л.Амарзаяа “*Радио нэвтрүүлэгт дүрслэлийн нөлөө*”¹ өгүүлэлдээ радио нэвтрүүлэгт үгээр, дуу хөгжмөөр, чимээ шуугианаар дүрслэхийн чухлыг онцлон өгүүлсэн байдаг. Гэтэл дүрслэх яриа хэмээх хамгийн чухал нэгэн элементийг нэмж өгүүлмээр санагдана.

Сэтгүүлч хүн оготнын нүхнээс ч сонин хачин зүйлийг олоод харчих овсгоотой гэдэг ч хүрч чадахгүй газар, очиж үзээгүй орчин бишгүй. Зарим нэг нь сэтгүүлч очиж үзээгүй онцгой объект ч гэж бий. Гурван зуун метрийн гүнд ажиллаж байгаа уурхайчны амьдралыг сурвалжлахын тулд заавал дүүжин шатаар уруудан уурхайн гүнд очих албагүй. Эсвэл хотоос хол хөдөө болсон том осол, гамшгийг олон түмэнд мэдээлэхийн тулд заавал ослын газар очих гээд зүтгээд байх шаардлагагүй. Ийм нөхцөлд эх сурвалжийн дүрслэх яриа ашиглаж болно.

Ерээд оны эхээр Хөвсгөлийн хөвч тайгаар аялсан нутгийн нэгэн хүний хууч яриаг Монголын радиогоор нэвтрүүлж орон нутгийн сонинд нь нийтэлжээ. Тэр хүний яриаг соронзон хальсанд буулгасан байдлаар нь сэтгэл хөдлөл, дуу алдалттай нь, аялга үгтэй нь оруулсан байна.

“Дээр үед бидний өвөг дээдэс ар давж булганы ан, наймаа хоёрт явдаг байсан тэр жимээр давж Тагнын таван давааны нэгээр давлаа. Тэнд ургасан хоёр хушны мөчир хоорондоо зөрөөд доогуураа харанхуйлчихсан, ерөөсөө нар харагдахгүй. Үнэн гоё орчлон тэнд байна аа... Бидний очсоны маргааш тэнд цас орсон. Есдүгээр сарын хорьдын орчим шүү дээ. Цас нь моддын орой мөчир шилмүүс дээр тогтчихсон. Газартаа хүрээгүй. Бүүдийсэн гэрэлтэй байшинд орчихсон юм шиг. Тэнд тогооны боролзгоно нов ногооноороо, шар цэцэг нь яг хэвээрээ, үгүй мөн гоё!!! Пээ, та нар явж үзсэн ч болоосой. Цааш явтал мэдрэл сульдуулсан хачин үнэр. Жодоо модны үнэр үү, бүү мэд. Тэгснээ нэг их сайхан, бараг л “духи” гэмээр гайхамшигтай үнэр. Ёстой ч юу ч гэхэв дээ. Гэхдээ тэнд дуртай аавын хүү гозойтол давхиад очих газар яавч биш. Хад асга, хавцал уйтан, бартаа нуранги, бургас харгана ч ёстой нэг байна аа. Нууц товчоонд

* МУИС-ийн Монгол хэл, соёлын сургуулийн Утга зохиолын тэнхим

¹ МУИС. ЭШБ № 206 (18) НУФ, Улаанбаатар, 2003, 82-85 дахь тал

цатгалан могой шургаж чадахгүй балар шигүү ой гэж гардаг. Яг тийм балар тайгад очиж үзлээ. Ёстой ямар гэж санана. \дуу алдав\ Явж үзээгүй хүнд үгээр илэрхийлж болохгүй байна”² гэх мэтчлэн ярьжээ. Тавагны амсар шиг том навч, хөрсөн дээр нь ямар ч шавьж үзэгдэхгүй хөлдөж байгаа тухай, хүн гээчийг үзээгүй гөрөөс буга согоо, үргэж айх жийрхэхээ мэдэхгүй ангайтал хараад зогсож байсан зэргийг өгүүлэгч нүдэнд харагдтал дүрслэн ярьсан байна. “Еэ би та нарт дүрслэн өгүүлж чадахгүй байна. Миний үгийн баялаг, илэрхийлэх чадвар ёстой нэг дутаж байна” хэмээн өгүүлсэн байна. Радио, телевизийн уран бүтээлчид цэвэр сайхан яриа тайлбар үзүүлж, сонсох гээд оролцогчийн сэтгэл хөдлөл, дуун алдалтыг хасчихдаг гэм бий. Сонин сэтгүүл дээр ч сул үг, зогсоц зэргийг орхиж бичгийн хэлэнд ойртуулан нийтэлдэг. Гэтэл эх сурвалжийн дуу алдалт, зогсоц \чимээгүй болох\, цочир асуултад хариулж чадахгүй балмагдан сандчих, тохирсон үгээ олохгүй ээрэн түгдрэх зэрэг бүгд учир утгатай бөлгөө. Ярих үеийн дуу хоолойны өөрчлөлтийг илэрхийлдэг аялга нь өнгө аяс, хөг болон тэдгээрийн олон хэлбэрүүдийн тусламжтайгаар биелэлээ олж хамгийн нарийн, үл анзаарагдам, төвөгтэй мэдрэмжийг гайхамшигтай илэрхийлдэг.

СГЗ, ахмад сэтгүүлч Х.Цэвлээ “Өвөөгийн жор” номондоо “Ёо ёо яасан яршигтай юм бэ?! Наадахыгаа болиод өгөөч. Өөв миний хүү юу гэв? Уухай даа, их сайн байна. Хөөе чамд чих байна уу?, Пөөх яасан муухай амьтад вэ?, Ай халаг даанч дээ, Эй чаавас тэр хүний байгааг дээ, Ёох яасан хэцүү юм бэ гэх маягаар үйл явдлын дүрслэлийг аялга үгээр завсар хооронд нь чимэглэж өгөхөд илүү амьдралд ойртож ирдэг”³ гэж хүч нэмэгдүүлэх, яриа хөөрөөг амттай сайхан болгодог өөв, ай, эй, хөөе, хүүе, ёх, үүхай, үүхайс даа, тий тий, халхай, ёо ёо, нээ, пөөх, ээ чаавас зэрэг үгсийг онцгойлон дурдсан байна. Дуугүй байна гэдэг яриа дунд онцгой содон илэрхийлэл. Радиогийн нэрт сэтгүүлч, СГЗ Б.Цэдэндамба ярилцлага өгөхгүй гэсэн эх сурвалжид хандан “Та үг хэлэхгүй, хариулт өгөхгүй гэдгээ монголын сонсогчдод хэлчих” гээд микрофон тулгахад нөгөөх нь сандарч нэг гараараа амаа таглаад, нөгөө гараараа дуун цацруулагчийнх нь толгойг базаад “Мн... мн.. мг” гээд сандарч байсан гэдэг. XIX зууны Английн нэрт зохиолч сэтгэгч Карлейль «Ярих, дуугүй байх хоёр харилцан үйлчлэхдээ хамтран нөлөөлж, хоёр давхар утга илэрхийлдэг. Хэрэв үг хэлэхийг аугаа хэрэг гэвэл дуугүй байх нь түүнээс аугаа хэрэг юм. Хүн дуугүй байх авьяасыг эзэмшсэн байх ёстой» гэсэн байдаг. Тиймээс дуугүй байна гэдэг эх сурвалжийн нэг хандлага. Түүнийг яг тэр чигээр нь оруулах ямар байдалтай байгааг нь дүрсэлж хэлэх нь чухал. Телевизээс бусад хэрэгслийн \сонин, сэтгүүл, радио зэрэг\ бүтээлд сэтгүүлч өөрөө оролцоогүй бол үйл явдал, үзэгдлийг сонирхолтой үзүүлж харуулахын тулд “Тэгээд юу болсон, ямар харагдаж байна, танд юу бодогдож байв, ямар байдалтай байсныг та дүрслээд хэл дээ” гэж мэтээр үзэгдэхүйц байдлыг онцлон дүрслүүлж болно.

Монголын радиогийн нийслэлийн редакцийн “Нигүүлсэнгүй сэтгэл” цувралын нэгэн дугаараар нисэхэд насаараа шахам ажилласан Магсар, түүний гэр бүл Сосор нар ад үзэгдсэн хар хүүхдийг өргөж авсан тухай сонирхолтой яриа байна.

Наяад оны эхээр Орост сурч байсан нэгэн монгол охин африк залуугаас хар хүүхэд олжээ. Төрөөд таван сар болсон буржгар үстэй бондойсон жаалаа тэврээд иртэл Намын

²) “Ч.Нямсүрэнгийн яриа” Дархад зоны “Маанар” сонин 1996 № 3

³) Х.Цэвлээ “Өвөөгийн жор” Уб, 2012, 51-52 дахь тал

Төв Хороонд ажилладаг аав, насаараа багшилсан ээж хоёр нь охиноо ажилд оруулан хүүхдийг нь ад үзэн харанхуй өрөөндөө байлган усаар угжих болжээ. Хоёрхон сарын дараа хүүхэд эцэж тураад яс арьс болсон байна. Яг ийм үед нь энэрэнгүй сэтгэлтэй хоёр хүн таарчээ. Энэ тухай эх сурвалжийн яриаг соронзон хальсанд буусан байдлаар нь оруулья.

-Манайх арван гурван хүүхэдтэй айл байсан. Гэтэл нэг нь эндээд арван хоёр болсон л доо. Нэг өдөр манай хоёр банди, ээжээ хүүхэд өргөж авъя, хотод нэг хөөрхөн хүүхэд байна гэлээ. Юун хүүхэд өргөж авах. Түрүүчийнх нь баас шээснээсээ салаагүй байхад (манай хамгийн бага хоёр ойттой байлаа.) юу ярьж байгаа юм гэлээ. Үгүй, яадаг юм ээжээ, аягүй хөөрхөн хүүхэд үхэхээ шахаж байна, түүнийг өргөж авъя гээд хоёр талаас зэрэг зэрэг шаллаа. Энэ чинь юун солиотой юм, үхэхээ шахсан хүүхэд гэж юу яриад байна, та хоёр миний мууг үзэх гээгүй юм бол тийм хүүхэд авчраад яах гэв. Тэр аавдаа хэл, аав чинь мэднэ гэв. Тэгээд л гал зууханд юм хийж байлаа. Аавдаа очоод л хэлж байгаа бололтой. Та нар нохойн гөлөг авчраад л тэжээгээд байдаг. Хамаа байна уу, тийм аргагүй хүүхэд байгаа бол аваад л ирэхгүй юу гэж байгаа бололтой. Би цаашлуулаад та хоёр өөрсдөө маллах юм уу гэлээ.

Маргааш нь Октябрийн баярын өдөр байсан юм. Намайг зэмлэсэн болохоор тэгсэн ч юм уу нөгөө хоёр маань жагсана гээд бужигнаж байснаа, ээжээ, бид хоёр хүүхэд авчирна шүү гээд дүү нь хэллээ. Та хоёрт хүүхдээ өгөөд явуулж байдаг амьтан хаа байсан юм гээд би тоосонгүй. Тэр хоёр ч пижигнээд гараад явчихлаа. Аав нь өглөө босоод “За өнөөдөр манайд зочин ирнэ идээний юм авна” гэнэ. Тэгээд өвгөн яваад дэлгүүрээс боов чихэр аваад ирлээ. Хоёулаа зурагтаар баярын жагсаал хараад сууж байтал чинь хонгилд юм пижигнээд явчихлаа. Харсан чинь манай хоёр ногоон цэмбэн бүтээлэгт боодолтой юм тэврээд орж ирж байна. Би ч хүүе юу вэ? гээд л дуу алдлаа. Цаана нь хүн алга. Манай хоёр за нөгөөдөхийг аваад ирлээ, задлах уу ээжээ гэлээ. Задаллаа. Хөөрхий амьтан эцэнхий туранхай ч гэж хачин. Толгойн ар нь цоорчихсон, яс арьс хоёр л орж ирсэн. Үнэр танар ч гэж жигтэйхэн. Хүний үр юм даа, энэ чинь гэж бодохоос хоёр нүднээс нулимс асгараад байлаа. Би ч уйлаад... тэгээд угаах боллоо. Хар усаар угаалтай биш сүү хярамлаж байгаад халаагуурын дэргэд аваачаад угаалаа. Нүүрийг нь угааж байхад хэл нь цухалзаад, уруул амаа завсаргүй долоогоод, ёстой нэг цагаан юмны бараа хараагүй амьтан шиг л байлаа. Үгүй та хоёр чинь яаж яваад хаанаас ийм амьтан олоод ирэв ээ, гэсэн чинь манай хоёр банди ам уралдан ярьж гарав. Тэр айлд яваад очсон чинь идээ будаа засчихсан байв. Нэг өвөө, та нар хүүхэд авахаар ирсэн үү гэж байна. Тиймээ л гэсэн. Цаанаас нэг хөгшин гарч ирээд за та нар авах гэж байгаа бол аваад яв гээд жижиг өрөөнд орлоо. Хойноос нь дагаад орсон чинь орон дээр атийсан хар хүүхэд хэвтэж байсан. Эмээ нь нэг даавуунд ороогоод, хулдаас ноосон хөнжилд боож өгөөд гадаа машинд суу, хүргэж өгнө гэсэн. Тэгээд гарч явтал наадах чинь хар уснаас өөр юм идэж ууж үзээгүй хүүхэд шүү гэсэн. Тэгээд л хүрээд ирсэн юм. Хоёр хүү маань ингэж л яваад ирсэн юм. Аажим аажимаар дасгасаар сүүнд орсон. Ирсэнээ бодоход унтдаг болж байна. Нэг юмнаас айчихсан юм шиг л бүлтэгнээд л унтаж чадахгүй байсан... гэж тэр эх ярьж байна. Үүнд ямар ч завсар орсонгүй. Яг нь ярьсан чигээрээ. Сэтгүүлч нь яриаг нь тасалж, үйл явдал, үргэлжлэх амттай хэсгийг үймүүлсэнгүй. Тэр эх хөөрхий нялх амьтныг зогсоо зайгүй асарч байж хүн болгож авчээ. Цээжин биед нь хонины сүүлний тос түрхээд эргээд ар талд нь түрхэхээр урд тал нь хув хуурай болчихдог. Хүний бие тэгэж хатдаг юм байлаа гэж нэмж өгүүлжээ. Зон

олны дунд энэ мэт сайхан яриатай жирийн хүмүүс олон бий. Түүнийг хадгалж үлдээж авах нь сэтгүүлч, зохиолчдын үүрэг.

1981 оны 4 дүгээр сарын эхээр Хөвсгөл аймгийн Баянзүрх суманд их цас унажээ. Сум нэгдлийн дарга Н.Жигжгээ \хожим нь гавьяат нэгдэлчин болсон\ сууриудаар явж, цас багатай нутаг уруу нүүлгэх ажил зохион байгуулж эхэлсэн байна. Гэтэл Дэлгэрмөрөний салбар уулын оройд нутаглаж байсан дархад малчин Доржгоо,

-Өндөр хүний өвдөг, ахар хүний аарцагаар татсан цасанд яаж бууж ирэх юм гэхэд Жигжгээ дарга муухан мушилзаж,

-Мн. Монгол хүн хязгаар хярхаггүй сансарт нисээд бууж ирж байх, та \хүнийг дандаа ахачлана\ энэхэн уулын оройгоос бууж чадахгүй байх таарч дээ гээд хэлэх үггүй болгож үгэндээ оруулсан гэдэг. Энэ жаахан ярианд малчин эрийн “Өндөр хүний өвдөг, ахар хүний аарцагаар татсан цас” хэмээн адарч, хэгжүүрхэж байхад, хариу барьсан Жигжгээ монгол хүн сансарт ниссэн хосгүй үйл явдалтай нүүх үйлийг харьцуулан ам таглаж байгаа аль аль нь оновчтой юм. Хошин шогт дуртай дархад нутгийн орчин үеийн шог гэмээр нэгэн үг мөн ам дамжин яригдсаар гуч гаруй жил болж байна.

“Жүгдэрдэмидийн Гүррагчаа сансарт ниссэн тэр өдөр

Жүрмэдийн Дэмбэрэлийн Гэндэн Хийтэд согтуу байлаа”⁴ гэсэн үгэнд архи уухаа ид бах болгон сансарт ниссэн үйл хэрэгтэй адилтгасан ч овог нэрийн ойролцоо хэлэгдэх байдал Хийт хэмээх газрын нэрийг сансар хэмээх уудам оронтой адилтгасан зэрэг нь энэ хоёр шадыг “урт наслахад” хүргэжээ. Гэндэн гуай бурхны орноо заларсан ч хэлсэн үг нь зон олны дунд “амьдарсаар”...

Эцэст нь эх сурвалжийн дүрслэх ярианд:

1. Ардын амьд хэлээр яриаг нь тэр хэвээр оруулах
2. Сэтгэл хөдлөл, нүүрний хувирал өөрчлөлтийг аль болох тусгаж өгөх
3. Сэтгүүлчийн санаачлага, бүтээлч оролцоотой дүрслэлийг аль болохоор бий болгох. Энэ нь аль болох зураглал хийлгэх, дүрслэх асуултаар өдөөх
4. Радиод чимээ шуугиан, сонин хэвлэлд цэг, тэмдэг ашиглан зогсоц, сэтгэлийн аяс хандлагыг шингээх
5. Уран яруу хэрэглүүр \адилтгал, зүйрлэл, ихэсгэл, багасгал, тойруулал, егөөдөл гэх мэт\ ашиглаж оролцогчоо дэмжих гэх мэт хэдэн зүйлээр амьдруулан хэрэглэх нь сэтгүүлчдийн хэл яриаг сайжруулах, ардын яруу сайхан хэлний өв үндэс болсон дүрслэлийг хадгалан үлдэхэд тус нэмэртэй юм.

⁴) Дархад зоны “Маанар” сонин 1993 № 01

НОМЗҮЙ

1. МУИС, ЭШБ¹ 206 (18), НУФ, Улаанбаатар, 2003.
2. Дархад зоны “Маанар” сонин, 1993, № 01
3. “Ч.Нямсүрэнгийн яриа”, Дархад зоны “Маанар” сонин, 1996, № 03
4. Х.Цэвлээ, “Өвөөгийн жор”, Улаанбаатар, 2012,

ABSTRACT

Figurative speech is a special and important element of literary imagery. A journalist who himself hasn't taken part in the activity must listen to what others say and felt about an event. It very important for him to use folk colloquialisms, real emotion, and literary imagery, which can only be obtained through interviews and research.